



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/24

Амардалай

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын 6 дугаар зүйлийн 6.1, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2019 оны А/04 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дэлгэр-Эмт багийн "Суварга"-т малын гоц халдварт бог малын "Мялзан" өвчний эмнэл зүйн шинж тэмдэг 36 хоногийн хугацаанд илрээгүй, голомтын болон сэжигтэй бүсийн бог малд 31 хоногт эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй тул сумын Засаг даргын Хорио цээрийн дэглэмийг хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай А/21 дүгээр захирамжийг хүчингүй болгож, хорио цээрийн дэглэмийг цуцалсугай.

2. Өвчтэй малтай хамт байсан болон өвчлөөд эдгэрсэн малыг 3 сарын хугацаанд өөр сумын нутаг дэвсгэрт шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, малчдад малын өвчний талаар анхааруулга, сэрэмжлүүлэг өгч, малд тухай бүр клиник үзлэг хийж, холбогдох албан газарт мэдээлэл өгч ажиллахыг "Дэлгэрбаяндалай", "Арвин тэгш баялаг" хувийн хэвшлийн мал эмнэлгийн эмч нар, багийн Засаг дарга нарт даалгасугай. .

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ